



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

## ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагаа 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 16.30 цагт Төрийн нарийн бичгийн даргын хуралдааны танхимд боллоо.

Ёслолын ажиллагаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Т.Гантогтох, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Батмөнх, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Алтансүх, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал нар оролцлоо.



Төрийн захиргааны албан хаагчаар томилогдсон Жижиг, дунд үйлдвэрийн газрын Бүртгэл, мэдээлэл, нэг цэгийн үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Чинбат “Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангарагаяа. Тангарагаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ” хэмээн Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөлөө.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ